

“АЧИТ АЛХАБЫ” ХК-НЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 04 сарын 30 өдөр

Өлгий хот

“Ачит Алхабы” ХК компанийн 2022 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 2023 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 10⁰⁰ цагт “Мирас” ЗБН-ийн байранд боллоо.

Хурлыг тус компанийн ТУЗ-ийн дарга К.Ахжархын нээж үг хэлэв. Монгол улсын компанийн тухай хууль, санхүүгийн зохицуулах хорооны журам болон бусад холбогдох хууль журмын дагуу хурал хуралдуулах тухай зарыг “Өнөөдөр” сонины 2023 оны 3 дугаар сарын 22-ны, 4 дүгээр сарын 06-ний өдрийн дугаарт хэвлүүлэн зарлал хүргэв. Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-тай үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ байгуулж 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөр тасалбар болгон хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй судалгааг гаргуулж ажилласан тухай танилцуулж хурлыг нээв.

Тус ээлжит хурлаар доорхи асуудлыг хэлэлцэв. Үүнд:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт,
2. 2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
3. Компанийн 2023 оны төлөвлөгөө, төсөв батлах
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батлах

Тус компанийн нийт 74127 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдээс 60646 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигч К.Ахжархын БЮ94021014 12914 ширхэг хувьцаа, Х. Калимат УУ65022419 20389 ширхэг хувьцаа, К.Али БЮ05313017 14430 ширхэг хувьцаа, К.Алуа БЮ96101109 12913 ширхэг хувьцаа буюу нийт хувьцаа эзэмшигчдийн 81,8 хувь нь оролцов.

Тус компанийн томоохон хувьцаа эзэмшигч Ч.Ана /УЕ66042700/ 11037 ширхэг хувьцаа эзэмшидэг ба одоо Казахстан улсад амьдардаг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцохоор тохиролцсон боловч эрүүл мэндийн шалтгаанаар оролцож чадсангүй.

Хурлын дотоод журмын дагуу Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг Гүйцэтгэх захирал Х.Калимат танилцуулав.

Компаний 2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг ТУЗ-ийн дарга К.Ахжархын танилцуулж хэлэлцүүлэв.

Компанийн 2023 оны төлөвлөгөө, төсөв батлах талаар ТУЗ-ийн дарга К.Ахжархын танилцуулж хэлэлцүүлэв.

Компаний ТУЗ-ийн гишүүнд дэвшигчдийг талаар ТУЗ-ын нарийн бичгийн дарга Х.Халамхан танилцуулж хэлэлцүүлэв.

Үүнд: ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигч Х.Халамхан, Т.Далелхан, А.Еркеш, Е.Жанбота, Б.Айтолхын нарын, ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигч Х.Калимат, К.Ахжархын, К.Алуа, К.Али нарын хүмүүсийг тус тус дэлгэрэнгүй танилцуулж хэлэлцэв.

Дээрхи асуудлуудтай холбоотой ямар нэгэн санал, шүүмжлэл гараагүй бөгөөд саналын хуудсаар дээрх 4 асуудлуудыг шийдвэрлэн санал хураасан болно.

Нийт ирсэн саналын хуудсыг үндэслэн дараах шийдвэр гаргав:
Тооллогод нийт хувьцаа эзэмшигчдийн 81,8 хувь буюу 60650 ширхэг хувьцаа эзэмшиж буй 4 хувьцаа эзэмшигчдийн саналын хуудас ирсэнээс 4 буюу 100 хувь хүчинтэй байлаа.

Кумулятив аргаар өгөх саналын эрх нийт 60646 саналын хуудсаар

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг 100 хувийн саналаар зөвшөөрсөн ба татгалзсан, түтгэлзсэн санал үгүй байна.
2. 2022 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг 100 хувийн саналаар зөвшөөрсөн ба татгалзсан, түтгэлзсэн саналгүй учир батлав.
3. Компанийн 2023 оны төлөвлөгөө, төсөвийг 100 хувийн саналаар зөвшөөрсөн ба татгалзсан, түтгэлзсэн саналгүй учир батлав.
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг батлах тухай ТУЗ-ийн тогтоолыг 100 хувийн саналаар зөвшөөрсөн ба татгалзсан, түтгэлзсэн саналгүй учир батлав.

Тэмдэглэл хөтөлсөн: ... Х.Халамхан

Танилцсан: Хурлын дарга ... К.Ахжархын

